ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Соёлын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2025/096/НА-СТА-ТШ3**


Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2025 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4207 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК
Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг
Утас: 88883776 Цахим хаяг:khaanconsultingaudit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.24 № 213

танай 2025.01.24-ны № 1-т

ДОРНОД АЙМГИЙН ЦАГААН-ОВОО СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ДАРГА Б.ГАНЦЭЦЭГ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Соёлын төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Жилийн эцсийн бараа материал 45,173.8 мянган төгрөгийн хөрөнгийн тооллого хийгээгүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна, 12.2-т Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ, 12.2.1-д Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

011022131

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудал**

Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Соёлын төвийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилго, 4 зорилт, 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын Засаг даргын тамгын газраас 86.0 хувьтай үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **63,274,567.10** | **45,173,892.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 24,399,595.10 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **38,874,972.00** | **45,173,892.00** |
| **351** | **Түүхий эд материал** | 24,475,230.00 | 29,775,130.00 |
| 35100 | Тусгай зориулалттай материал | 24,475,230.00 | 29,775,130.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **14,399,742.00** | **15,398,762.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 14,399,742.00 | 15,398,762.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **980,858,118.02** | **869,918,293.58** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **890,858,118.02** | **869,918,293.58** |
| **392** | **Биет хөрөнгө** | 881,806,175.02 | 860,885,689.29 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 881,806,175.02 | 881,806,175.02 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (136,651,470.01) | (169,094,937.37) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 133,043,613.62 | 149,139,298.62 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (70,579,414.83) | (66,178,614.03) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 75,541,679.71 | 75,541,679.71 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (30,628,819.74) | (37,507,912.66) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 2,625,000.00 | 2,625,000.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (2,515,000.00) | (2,515,000.00) |
| 39213 | Түүх соёл,музейн дурсгалт зүйлс | 1,170,000.00 | 1,170,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 28,000,000.00 | 28,000,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | | (2,100,000.00) |
| **393** | Биет бус хөрөнгө | 9,046,354.25 | 9,032,604.29 |
| 39301 | Програм хангамж | 55,000.00 | 55,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (28,645.75) | (42,395.71) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 9,020,000.00 | 9,020,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **954,132,685.12** | **915,092,185.58** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **954,132,685.12** | **915,092,185.58** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **954,132,685.12** | **915,092,185.58** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 316,275,610.20 | 316,275,610.20 |
| 51101 | Өмч:  - төрийн | 9,020,000.00 | 9,020,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 305,587,427.50 | 266,546,927.96 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 279,453,238.75 | 305,587,427.50 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 26,134,188.75 | (39,040,499.54) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 323,249,647.42 | 323,249,647.42 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **954,132,685.12** | **915,092,185.58** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **301,882,832.98** | **378,012,939.11** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **47,400,000.00** | **22,984,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **47,404,000.00** | **22,984,000.00** |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 47,404,000.00 | 22,984,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **254,478,832.98** | **355,028,939.11** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | | **239,464,539.11** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 239,464,539.11 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **8,156,000.00** | **4,664,000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 131105 | Төсөв байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 8,156,000.00 | 4,664,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | **97,822,000.00** | **110,900,400.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага/ | 97,822,000.00 | 110,900,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **275,748,664.23** | **417,053,438.65** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **275,748,644.23** | **417,053,438.65** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **268,432,750.57** | **349,286,042.47** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **97,425,396.80** | **157,782,341.97** |
| 210101 | Үндсэн цалин | 78,443,015.28 | 106,381,181.97 |
| 210102 | Нэмэгдэл | 10,051,057.30 | 36,733,003.00 |
| 210104 | Урамшуулал | 8,931,324.22 | 14,668,157.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **12,151,710.65** | **19,629,121.91** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 8,269,392.23 | 13,513,499.33 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 972,875.12 | 1,492,955.70 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 778,302.43 | 746,477.91 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 185,382.15 | 744,251.91 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,945,758.72 | 3,131,937.06 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **94,532,666.34** | **93,996,699.15** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,037,311.10 | 2,317,419.15 |
| 210302 | Түлш, халаалт | 91,995,355.24 | 91,679,280.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 500,000.00 | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **7,228,651.62** | **6,630,475.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,606,100.00 | 1,265,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,436,200.00 | 2,122,075.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 502,451.62 | 666,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 180,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,683,900.00 | 2,396,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | **3,000,000.00** |
| 210604 | Урсгал засвар | | 3,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | **1,190,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | | 1,190,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,248,800.00** | **5,620,380.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,068,800.00 | 4,494,380.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээ | 1,800,000.00 | 1,126,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **54,845,525.16** | **61,437,024.44** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,228,891.00 | 3,865,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 51,616,634.16 | 57,572,024.44 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **7,315,893.66** | **67,767,396.18** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **5,026,560.00** | **9,575,800.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тнтгэмж, урамшуулал | | 1,517,800.00 |
| 213209 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг | 4,258,560.00 | 7,278,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 768,000.00 | 780,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас санхүүжилт** | 2,289,333.66 | 6,326,500.85 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,289,333.66 | 6,326,500.85 |
| 2135 | Төсвийн захирагчаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 51,865,095.33 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 51,865,095.33 |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **26,134,188.75** | **(39,040,499.54)** |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **26,134,188.75** | **(39,040,499.54)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **254,478,832.98** | **355,028,939.11** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **254,478,832.98** | **355,028,939.11** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | | **239,464,539.11** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 239,464,539.11 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **8,156,000.00** | **4,664,000.00** |
| 131105 | Төсөв байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 8,156,000.00 | 4,664,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | **97,822,000.00** | **110,900,400.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/ | 97,822,000.00 | 110,900,400.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | **148,500,832.98** | |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 148,500,832.98 | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **230,387,710.07** | **379,428,534.21** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **230,387,710.07** | **379,428,534.21** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **223,071,816.41** | **311,661,138.03** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 97,425,396.80 | 157,782,341.97 |
| 210101 | Үндсэн цалин | 78,443,015.25 | 106,381,181.97 |
| 210102 | Нэмэгдэл | 10,051,057.30 | 36,377,003.00 |
| 210103 | Урамшуулал | 8,931,324.22 | 14,668,157.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **12,151,710.65** | **19,629,121.91** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 8,269,392.23 | 13,513,499.33 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 972,875.12 | 1,492,955.70 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 778,302.43 | 746,477.91 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 185,382.15 | 744,251.91 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,945,758.72 | 3,131,937.06 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **94,532,666.34** | **93,996,699.15** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,037,311.10 | 2,317,419.15 |
| 210302 | Түлш, халаалт | 91,995,355.24 | 91,679,280.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 500,000.00 | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **4,136,751.62** | **4,795,495.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,098,100.00 | 900,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,436,200.00 | 1,349,875.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 502,451.62 | 666,600.00 |
| 210404 | Ном хэвлэл | - | 999,020.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 180,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,100,000.00 | 700,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **-** | **500,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,611,700.00** | **17,797,500.00** |
| 210601 | Багаж техник хэрэгсэл | 2,611,700.00 | 15,397,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 2,400,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **-** | **1,190,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 1,190,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **3,748,800.00** | **10,155,980.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,568,800.00 | 9,029,980.00 |
| 210806 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 180,000.00 | 1,126,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **7,464,791.00** | **5,814,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,464,791.00 | 5,814,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **7,315,893.66** | **67,767,396.18** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,026,560.00 | 957,580.00 |
| 213209 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг | 4,258,560.00 | 7,278,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 768,000.00 | 780,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | | **51,865,095.33** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 51,865,095.33 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | | (24,399,595.10) |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | | **(24,399,595.10)** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **24,399,595.10** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**/төгрөгөөр/**

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **325,295,610.20** | **323,249,647.42** | **305,587,427.50** | **954,132,685.12** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | -- | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **325,295,610.20** | **323,249,647.42** | **305,587,427.50** | **954,132,685.12** |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | -- | - | -- |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (39,040,499.54) | (39,040,499.54) |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **325,295,610.20** | **323,249,647.42** | **266,546,927.96** | **915,092,185.58** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/төгрөгөөр/**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **11000** | **Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл** | **-** | **24,399,595.10** | -- |
| **11100** | **Үүнээс: Банкин дахь харилцах дансны үлдэгдэл** | **-** | **24,399,595.10** | |
| **71702** | **Соёл урлаг** | **253,151,700.00** | **276,705,334.21** | (23,553,634.21) |
| **80101** | **Үндсэн үйл ажиллагааны зардал** | **224,465,000.00** | **248,863,704.12** | (24,398,704.12) |
| **12** | **Татварын бус орлого** | **224,465,000.00** | **224,465,000.00** | - |
| **12200** | **Тусламжийн орлого** | **224,465,000.00** | **224,465,000.00** | - |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 224,465,000.00 | 224,465,000.00 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **224,465,000.00** | **248,863,704.12** | (24,398,704.12) |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **224,465,000.00** | **196,999,538.88** | 27,465,461.12 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **224,465,000.00** | **196,999,538.88** | 27,465,461.12 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **178,439,800.00** | **156,433,141.97** | 22,006,658.03 |
| 210101 | Үндсэн цалин | **109,271,100.00** | **106,381,181.97** | 2,889,918.03 |
| 210102 | Нэмэгдэл | 55,986,900.00 | 36,733,003.00 | 19,253,897.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | | - |
| 210104 | Урамшуулал | 13,181,800.00 | 13,318,957.00 | (137,157.00) |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **22,305,200.00** | **19,460,521.91** | 2,844,678.09 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,516,400.00 | 13,398,799.33 | (11,882,399.33) |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,784,500.00 | 1,479,455.70 | 305,044.30 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 892,300.00 | 739,777.91 | 152,522.09 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 892,300.00 | 737,551.91 | 154,748.09 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,568,700.00 | 3,104,937.06 | 463,762.94 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **5,100,000.00** | **3,945,495.00** | 1,154,505.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 600,000.00 | 600,000.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,000,000.00 | 999,875.00 | 125.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,500,000.00 | 666,600.00 | 833,400.00 |
| 210404 | Ном хэвлэл | 1,000,000.00 | 999,020.00 | 980.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 500,000.00 | 180,000.00 | 320,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 500,000.00 | 500,000.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | **500,000.00** | **500,000.00** | - |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 500,000.00 | 500,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **11,350,000.00** | **11,350,000.00** | - |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 11,350,000.00 | 11,350,000.00 | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,300,000.00** | **1,190,000.00** | 110,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,300,000.00 | 1,190,000.00 | 110,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **3,470,000.00** | **212,080.00** | 3,257,920.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,000,000.00 | 994,380.00 | 5,620.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 150,000.00 | | 150,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,320,000.00 | 1,126,000.00 | 1,194,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,000,000.00** | **2,000,000.00** | - |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,000,000.00 | 2,000,000.00 | - |
| **26** | **Төвлөрүүлэх шилжүүлэг** | | **51,867,165.24** | (51,867,165.24) |
| **261090** | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 51,864,165.24 | (51,864,165.24) |
| **12** | **Татварын бус орлого** | **5,000,000.00** | **5,000,000.00** | |
| **12200** | **Тусламжийн орлого** | **5,000,000.00** | **5,000,000.00** | |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 5,000,000.00 | 5,000,000.00 | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,000,000.00** | **5,000,000.00** | |
| **21** | **Урсгал зардал** | **5,000,000.00** | **5,000,000.00** | |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **5,000,000.00** | **5,000,000.00** | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **5,000,000.00** | **5,000,000.00** | |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,000,000.00 | 5,000,000.00 | |
| **80802** | **Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэг** | **8,058,000.00** | **8,058,000.00** | |
| **12** | **Татварын бус орлого** | **8,058,000.00** | **8,058,000.00** | |
| **12200** | **Тусламжийн орлого** | **8,058,000.00** | **8,058,000.00** | |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 8,058,000.00 | 8,058,000.00 | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **8,058,000.00** | **8,058,000.00** | |
| **213** | **Урсгал зардал** | **8,058,000.00** | **8,058,000.00** | |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **8,058,000.00** | **8,058,000.00** | |
| 213209 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг | 7,278,000.00 | 7,278,000.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 780,000.00 | 780,000.00 | |
| **81855** | **Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт** | **10,118,700.00** | **10,119,530.09** | (830.09) |
| **12** | **Татварын бус орлого** | **10,118,700.00** | **10,118,739.11** | (39.11) |
| **12200** | **Тусламжийн орлого** | **10,118,700.00** | **10,118,739.11** | (39.11) |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 10,118,700.00 | **10,118,739.11** | (39.11) |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **10,118,700.00** | **10,118,739.11** | (39.11) |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **10,118,700.00** | **10,118,700.00** | - |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **10,118,700.00** | **10,119,530.09** | (830.09) |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,349,200.00** | **1,349,200.00** | - |
| 210104 | Урамшуулал | 1,349,200.00 | 1,349,200.00 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **168,600.00** | **168,600.00** | - |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,700.00 | 14,700.00 | - |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,500.00 | 13,500.00 | - |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,700.00 | 6,700.00 | - |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,700.00 | 6,700.00 | - |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 27,000.00 | 27,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **4,047,500.00** | **4,047,500.00** | - |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,047,500.00 | 4,047,500.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **3,035,600.00** | **3,035,600.00** | - |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,035,600.00 | 3,035,600.00 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,517,800.00** | **1,517,800.00** | - |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,517,800.00 | 1,517,800.00 | - |
| **26** | **Төвлөрүүлэх шилжүүлэг** | | **830.09** | (830.09) |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 830.09 | (830.09) |
| **83603** | **Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан** | **5,510,000.00** | **4,664,100.00** | 845,900.00 |
| **12** | **Татварын бус орлого** | **5,510,000.00** | **4,664,000.00** | 846,000.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **12000** | **Нийтлэг бус орлого** | **5,510,000.00** | **4,664,000.00** | 846,000.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын үндсэн орлого | 5,510,000.00 | 4,664,000.00 | 846,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,510,000.00** | **4,664,000.00** | 846,000.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,510,000.00** | **4,664,000.00** | 846,000.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **5,510,000.00** | **4,664,000.00** | 846,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **850,000.00** | **850,000.00** | - |
| 210401 | Бичиг хэрэг | 300,000.00 | 300,000.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 350,000.00 | 350,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 200,000.00 | 200,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **4,660,000.00** | **3,814,000.00** | 846,000.00 |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,660,000.00 | 3,814,000.00 | 846,000.00 |
| **26** | **Төвлөрүүлэх шилжүүлэг** | | 100.00 | (100.00) |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 100.00 | (100.00) |
| **1200** | **Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл** | | | - |
| **12100** | **Үүнээс: Банкин дахь харилцах дансны үлдэгдэл** | | | - |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 8.00 | 7.50 | 0.50 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 5.00 | 4.50 | 0.50 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 2.00 | 2.00 | - |

### 2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/төгрөгөөр/**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **80112** | **Нийтлэг үйлчилгээ** | **102,723,200.00** | **102,723,200.00** | **-** |
| 12 | **Татварын бус орлого** | **102,723,200.00** | **102,723,200.00** | **-** |
| **12200** | **Тусламжийн орлого** | **102,723,200.00** | **102,723,200.00** | **-** |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 102,723,200.00 | 102,723,200.00 | **-** |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **102,723,200.00** | **102,723,200.00** | **-** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **102,723,200.00** | **96,326,699.15** | **6,396,500.85** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **102,723,200.00** | **96,326,699.15** | **6,396,500.85** |
| **2103** | **БАЙР АШИГЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ** | **100,323,200.00** | **93,996,699.15** | **6,326,500.85** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,054,000.00 | 2,317,419.50 | 1,736,580.50 |
| 21302 | Түлш халаалт | 96,269,200.00 | 91,679,280.00 | 4,589,920.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,400,000.00** | **2,400,000.00** | |
| 210604 | Урсгал засвар | 2,400,000.00 | 2,400,000.00 | |
| **26** | **Төвлөрүүлэх шилжүүлэг** | | **6,326,500.85** | **(6,326,500.85)** |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 6,326,500.85 | (6,326,500.85) |

## 2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 89.8 сая төгрөгийн 3 алдаа[1] илэрснийг аудитын явцад залруууллаа.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

*Залруулсан алдаа:*

- Туслах үйл ажиллагааны орлогод бүртгэсэн 36.6 сая төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн дансанд бүртгэн орлогын дүнг залруулав. Энэ нь УСНББОУС 01, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Бараа материалын шинжтэй 1.3 сая төгрөгийн хөрөнгийг шууд зардалд бүртгэснийг залруулав. Энэ нь УСНББОУС 01, толилуулах батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Төвлөрүүлэх шилжүүлгийн 51.8 сая төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд нийт орлогын дүнд оруулсныг залруулав. Энэ нь УСНББОУС 01, толилуулах батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 45.7 сая төгрөгийн зөрчил[2] илэрсэнд 2 албан шаардлага хүргүүлэв.

### 2.1 Албан шаардлага

1. Нийт 16 цонхны шил солиход 0.6 сая төгрөгийн зардал гаргасан боловч 6 цонхны хагархайг нөхсөн нотлох баримтыг хавсаргасан байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, Төсвийн ерөнхий ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1-д Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан балансын гаргалт, тооллого тооцоо, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг өөрийн болон харьяа байгууллагадаа байнга шалган зааварчилж байх гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.
2. Жилийн эцэст бараа материалын 45.1 сая төгрөгийн тооллого хийгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ, 12.2.1-т Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Туслах үйл ажиллагааны орлогод бүртгэсэн 36.6 сая төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн дансанд бүртгэн орлогын дүнг залруулав | 1 | 36,632.2 | | | | | 1 | 36,632.2 | | | | |
| Бараа материалын шинжтэй 1.3 сая | 1 | 1,317.5 | | | | | 1 | 1,317.5 | | | | |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| төгрөгийн хөрөнгийг шууд зардалд бүртгэснийг залруулав | | | | | | | | | | | | |
| Төвлөрүүлэх шилжүүлгийн 51.8 сая төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд нийт орлогын дүнд оруулсныг залруулав | 1 | 51,865.0 | | | | | 1 | 51,865.0 | | | | |
| **Дүн** | **3** | **89,814.7** | | | | | **3** | **89,814.7** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Нийт 16 цонхны шил солиход гаргасан боловч 6 цонхны хагархайг нөхсөн нотлох баримтыг хавсаргасан байна. | 1 | 575.0 | | | 1 | 575.0 | | | | | | |
| Жилийн эцэст бараа материалын 45.1 сая төгрөгийн тооллого хийгээгүй | 1 | 45,173.8 | | | 1 | 45,173.8 | | | | | | |
| **Дүн** | **2** | **45,748.8** | | | **2** | **45,748.8** | | | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 307.2 сая төгрөгийн 26 гүйлгээний мэдээллийг ил тод байршуулаагүй | 1 | 307,193.8 | | | 1 | 307,193.8 | | |
| **Нийт дүн** | **1** | **307,193.8** | | | **1** | **307,193.8** | | |

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 171/19 128799 ДОА-2025/096/НА-СТА-ТШ3 Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цагаан-Овоо сумын Соёлын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын 16 цонхны хагархайг солихоор 920,000.00 төгрөгийн гүйлгээг харилцах данснаас хийсэн боловч 6 цонхны хагархай сольсон 575,000.00 төгрөгийн анхан шатны баримтыг хавсаргасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн *6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"* зарчим, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "Анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог, 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.2-т Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон хууль тогтоомжид харшилсан шийдвэрийг биелүүлэхээс татгалзах гэсэн заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн иж бүрэн ба нийцсэн байх батламж мэдэгдэл" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1 дэх *"нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй"* 4.2.1.11 дэх *"хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажил гүйлгээг анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж бүртгэх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Холбогдох хууль тогтоомж, журмыг мөрдөн ажиллахыг Цагаан-Овоо сумын Соёлын төвийн эрхлэгч Г.Гарамханд, нягтлан бодогч Н.Тогооч нарт даалгав.

2125040450

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Э.НАНДИНЧИМЭГ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 170/19625799 ДОА-2025/096/НА-СТА-ТШЗ Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цагаан-Овоо сумын Соёлын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд 45,173,892.00 төгрөгийн бараа материалын тооллогыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хийгээгүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 1-д "Үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн тооллогоор бэлэн байгаа үлдэгдэл, нягтлан бодох бүртгэлээр байвал зохих үлдэгдлийн хоорондын зөрүүг дор дурдсан журмаар тохируулан тооцно", 2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-т "Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.2 дох "*хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй*" 4.2.1.11 дэх "*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эд материал, үнэ бүхий зүйлийн тооллогыг хууль тогтоомжинд заасан хугацаанд хийж үлдэгдлийг тулган шалгах, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Хууль тогтоомж, холбогдох шийдвэрийг баримтлан ажиллахыг Цагаан-Овоо сумын Соёлын төвийн дарга Г.Гарамханд, нягтлан бодогч Н.Тогооч нарт даалгав.

2125040448

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Э.НАНДИНЧИМЭГ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 169/79125799 Чойбалсан хот
ДОА-2025/1096/ЧА-СТА-ЛЦ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цагаан-Овоо сумын Соёлын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 171 мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний 26 гүйлгээний 307,193,739.11 төгрөгийн мэдээллийг ил тод байршуулаагүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 1.2-т “Төрийн байгууллага, албан газар, төрийн өмчит хуулийн этгээд, үйлдвэрийн газар, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч (цаашид “байгууллага” гэх) нь шилэн дансны цахим хуудсанд Шилэн дансны тухай хууль болон энэ журамд заасны дагуу холбогдох мэдээллийг тавих үүрэгтэй” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11 дэх *”хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг мөрдөж мэдээллийг тогтмол тавих,

2125040445

биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан ажиллахыг Цагаан-Овоо сумын Соёлын төвийн дарга Г.Гарамханд, нягтлан бодогч Н.Тогооч нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Э.НАНДИНЧИМЭГ